



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Нийслэлийн Онцгой комиссын хурал 2021 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 13:00 цагт гишүүдийн ~~83.3~~ хувийн ирцтэй хуралдав.

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Хурлыг Нийслэлийн Онцгой комиссын дарга Д.Сумъяабазар даргалж, Өмнөд Африкаас гаралтай Ковидын шинэ хувилбарт Омикрон вируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, дархлаа сэргээх нэмэлт тунгийн вакцинжуулалтын талаар хэлэлцэж холбогдох асуудлаар үүрэг чиглэл өгөв.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад,  
Нийслэлийн Эрүүл мэндийн газарт

1.1. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас Өмнөд Африкаас гаралтай шинэ хувилбарт Омикрон вирус дахин халдварлуулах эрсдэл өндөр байгааг анхааруулсантай холбогдуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг яаралтай зохион байгуулж ажиллах.

Хоёр. Нийслэлийн Эрүүл мэндийн газарт

2.1. Дархлаажуулалтын нэмэлт тунгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, их дээд сургуулийн оюутнуудад хийгдэх нэмэлт тунг 2021 оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 03-ны өдрүүдэд шуурхай зохион байгуулах.

Гурав. Дүүргийн Онцгой комиссын дарга нарт,

3.1. Нийслэлийн 9 дүүргийн хороодод нэмэлтээр дархлаажуулалтын цэг ажиллуулахтай холбогдуулан байрны халдвар хамгаалал, хаягжуулалт, орчин нөхцөлийн бэлэн байдлыг хангуулж, дархлаажуулалтын ажилд дэмжлэг үзүүлэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.

Дөрөв. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэст

4.1. Шинэ хувилбарт вирусын талаарх зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээллийг иргэд олон нийтэд үнэн зөв тогтмол хүргэж ажиллах;

4.2. Хороодод нэмэлтээр дархлаажуулалтын цэг ажиллуулахтай холбогдуулан цэгийн байршлын мэдээллийг өдөр бүр бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд хүргэх.

ДАРГА



Д.СУМЪЯАБАЗАР